



БОЛОВСРОЛЫН САЙД
П.НАРАНБАЯР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2025.11.24 № 51

Хуулийн хэрэгжилтийн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 7-д Монгол Улсын иргэн “сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно...” гэж заасан. Гэвч өнөөдөр энэ эрхээ эдлэхэд амьдралын харилцан адилгүй нөхцөл байдлын улмаас бэрхшээл тулгарч байна. Алслагдсан орон нутагт амьдардаг, гоц авьяастай, уралдаан тэмцээнд байнгын бэлтгэлд байдаг, эрүүл мэндийн улмаас сургуульд сурах боломжгүй, эцэг эхээ даган шилжин суурьшиж явдаг, гадаад улс оронд оршин суугаа хүүхдүүдэд сурч боловсрох нөхцлийг бүрдүүлэх асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна.

Энэ асуудалд холбогдох зохицуулалт 2023 онд батлагдсан Боловсролын тухай багц хуульд тодорхой хэмжээнд туссан. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 22 дугаар зүйл 22.7 дахь хэсэгт “Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр бага боловсролыг гэрийн сургалтаар эзэмшүүлж болох бөгөөд гэрийн сургалт зохион байгуулах, түүнд хяналт тавих журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасан. Түүнчлэн Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.11 дэх заалтад “зайн болон цахим сургалт зохион байгуулах, эзэмшсэн боловсролыг үнэлэх, дүйцүүлэх журам батлах” гэж заасан. Гэвч хуулийн эдгээр зохицуулалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний үр дүн одоогоор тодорхойгүй байна. Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар дүн шинжилгээ хийхэд дээрх хоёр хуулийн заалтад холбогдох журам батлагдаагүй, бэлтгэл ажил явагдаж байгаа гэж Улсын Их Хурлын Тамгын газраас ирүүлсэн тайланд тэмдэглэжээ.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг үндэслэн бүрэн эрхийнхээ хүрээнд Танд дараах асуултыг тавьж байна.

1.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7-д заасан бага боловсролыг гэрийн сургалтаар эзэмшүүлэх талаарх бодлого, авч хэрэгжүүлж байгаа тодорхой арга хэмжээ;

2.Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.11-д “зайн болон цахим сургалт зохион байгуулах, эзэмшсэн боловсролыг үнэлэх, дүйцүүлэх журам батлах” гэж заасны дагуу авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний талаарх мэдээллийг ирүүлнэ үү.

2025000079

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд багтааж ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Б.ХЭРЛЭН

2025000079